



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 21,660,000.00 (хорин нэгэн сая зургаан зуун жаран мянган) төгрөгийн балансын үнэ, 21,132,737.89 (хорин нэгэн сая нэг зуун гучин хоёр мянга долоон зуун гучин долоон төгрөг наян есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, бригадын генерал Ц.Амгаланбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

 Ц.ТҮВШИНЗАЯА

0000105

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн
51 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА ХОРИХ АНГИ, ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ
АВТОМАШИН (трактор, чиргүүл)

Д/д	Автомашин нэр, марк, улсын бүртгэлийн дугаар	Ашиглалтанд орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1.403 дугаар нээлттэй хорих анги							
1	Мотоцикл (планета 5)	2008.03.19	280000	850,000.00	850,000.00	-	500,000.00
	Дүн			850,000.00	850,000.00		500,000.00
2."Авдрант хайрхан" ТӨААТҮГ							
2	Трактор (бага оврын, үйлдвэрийн дотроо)	2010.12.30	300000	2,500,000.00	2,095,237.89	404,762.11	1,000,000.00
	Дүн			2,500,000.00	2,095,237.89	404,762.11	1,000,000.00
3.Хөвсгөл аймаг дахь 443 дугаар нээлттэй хорих анги							
3	Фургон-УАЗ, 39-82 ХӨВ (арал 374100а0420820, хөдөлгүүр а0002224)	2010.12.30	350000	18,100,000.00	18,100,000.00	-	2,000,000.00
4	Чиргүүл (ЗИЛ-130, модон тэвштэй)	2017.12.27		210,000.00	87,500.00	122,500.00	150,000.00
	Дүн			18,310,000.00	18,187,500.00	122,500.00	2,150,000.00
	Нийт дүн			21,660,000.00 (хорин нэгэн сая зургаан зуун жаран мянган)	21,132,737.89 (хорин нэгэн сая нэг зуун гучин хоёр мянга долоон зуун гучин долоон төгрөг наян есөн мөнгө)	527,262.11 (таван зуун хорин долоон мянга хоёр зуун жаран хоёр төгрөг арван нэгэн мөнгө)	3,650,000.00 (гурван сая зургаан зуун тавин мянган)